



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/78

Рашаант сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний 382 дугаар тогтоолын 4, 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 3, 6, 9 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/69 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Соёлын төвийн даргын үндсэн цалинг ТҮСБ-5 1,620.000 (нэг сая зургаан зуун хорин мянган) төгрөг Эрүүл мэндийн төвийн даргын цалинг ТҮЭМ-6 1,540.000 (нэг таван зуун дөчин мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Шинэчлэн тогтоосон цалинг 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс тооцож олгохыг нягтлан бодогч (Н.Оюунгэрэл, Э.Амартүвшин) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ